

Засгийн газраас баталсан “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачин иргэдийн амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2009 оны эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл							
	Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо		2007 оны 10-р сарын 3-ны 255 дугаар тогтоол							
1.	Хөтөлбөрийн зорилго		Гэрийн тэжээвэр цаа бугын удмын сан, эрүүл мэндийг нь хамгаалж өсгөх, ашиг шимийг нь зохистой ашиглах замаар цаачдын ахуй нөхцлийг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.							
2.	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатны хугацаатай нь авч үзэх/	I үе шат – 2007-2011 он: Цаа буганд хийх мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах нөхцөл бүрдүүлж, иргэдэд амьдрал ахуйгаа дээшлүүлэх чиглэлээр цаачдад зориулан сургалт явуулж, эдийн засгийн дэмжлэг үзүүлж чадавхижуулах;	Цаа бугын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;							
		II үе шат – 2012-2015 он: Цөөн цаатай цаачин иргэд цаа бугаа өсгөн үржүүлэхийн зэрэгцээ өөр төрлийн мал аж ахуй болон бусад төрлийн бизнес эрхлэх, аялал жуулчлал хөгжүүлэх замаар бие даан ажиллаж, амьдрах таатай орчинг бүрдүүлэх.	Цаа бугын аж ахуй эрхэлж амьдардаг цаачин иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;							
			Цаачин иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.							
3.	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	Нийт 511.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.							
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/, үүнээс	167.4 сая							
		Тухайн жилд зарцуулсан	133.7 сая (62.5 + 50.0 + 21.2)							
4.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Нийт	100	90	70	50	30	10	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	3					2	1	
5.	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		Төлөвлөсөн	Гүйцэтгэл					Хувь	
	Шалгуур үзүүлэлт тус бүрээр	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг, түүний хэрэгжилтийн талаарх үнэлгээ;	Энэхүү шалгуур үзүүлэлтийг хангах талаар 2008 онд төлөвлөгдсөн ажил	ОХУ-ын Тува улстай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга тэргүүтэй 5 хүний					60.0 %	

		байхгүй	бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Тува улсын Ерөнхийлөгч, Хөдөө аж ахуйн сайд, Соёлын сайд, Боловсролын сайд, Гадаад харилцаа, эдийн засгийн газрын даргатай тус тус уулзаж, хоёр талын хамтын ажиллагааг эдгээр салбарт өргөжүүлэх талаар яриа хэлцэл хийн, талууд хооронд 2004 онд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай протокол бичиг, Тува улсын Тэс-Хэмскийн хошуутай хамтран ажиллах тухай хэлэлцээрийг хийж, хоёр талын хамтран ажиллах тухай хэлэлцээрийг тус тус байгуулсан байна.	
	Улсын хэмжээний цаа бугын тооны өсөлт, сүргийн бүтцийн зохистой харьцаа;	Цаа бугын тоо толгойг нэмэг-дүүлэх, удмын санг хамгаалах зорилгоор гадаад орноос цаа буга худалдан авах	Тува улсаас 5 эр цаа, 11 охин нийт 16 цаа авчирч цусны шинжилгээний дээж авч УМЭАЦТЛ-д хүргүүлэн шинжлүүлсэн.	100 %
	Тайгын “Соёл үйлчилгээний төв”-д түшиглэн зохион байгуулсан сургалтын төрөл, түүнд хамрагдагсад, худалдаа, үйлчилгээний цэгийн үйл ажиллагааны үр дүн, хүлээн авч үйлчилсэн жуулчны тоо;	2009 онд ЭМЯ, БОЯ, НХХЯ, БСШУЯ-тай хамтран ажиллахаар төлөвлөсөн.	Хүний эрхийн комисстой хамтран цаатан иргэдийг нарийн мэргэжлийн үзлэгт хамруулж, эмчилгээ орошлогоо хийх ажлыг зохион байгуулсны гадна Эрүүл мэндийн сайдын 2008 оны 107 тоот тушаалаар Цаачин иргэдийг эрүүл мэндийн оношлогоо шинжилгээнд хамруулах ажил	70.0 %

			хийгдсэн. Цагаан нуур сумаас их дээд сургуульд 6 хүүхэд суралцдаг бөгөөд тэдгээр оюутан хүүхдийн сургалтын төлбөр, дотуур байрны зардлыг шилжүүлэх ажлыг зохион байгуулав. Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ЗДТГ-тай хамтран “Цаатан фестиваль” зохион байгуулж	
	Цаа бугын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах болон цаачдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хэрэгжүүлсэн гадаад, дотоодын төсөл, гарсан үр дүн;	Цаа бугын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.	Цаа бугын үржил ашиг шим эрүүл мэндийн байдал, өсөлт хорогдолыг тооцох асуудлаар МААЭШХ, МЭАЦТЛ-иос мэргэжлийн хүмүүсийг жил бүр Цагааннуур суманд ажиллуулж цаа бугыг эрүүл мэндийн үзлэг, зарим халдварт өвчний шинжилгээнд хамруулж байгаа. 2009 оны үзлэг шинжилгээний үеэр халдварт өвчин илрээгүй байна. Энэ арга хэмжээний үеэр малын өвчний өргөн хэрэглээний эм болон тарилга туулгалтын эм бэлдмэлийг олгосон.	100 %
	Цаа бугын аж ахуй эрхлэгчдийн орлого болон амьжиргааны түвшингийн өсөлт, эрүүл мэнд, боловсролын үзүүлэлт;	Энэ шалгуур үзүүлэлтийг дүгнэх хугацаа болоогүй байгаа.	Цагааннуур суманд нийтдээ 376 Тува иргэн амьдарч байгаагийн 49 нь 0-8 хүртэлх, 80 нь 8-16 насны хүүхэд, 176 нь 16-55 насны, 31 нь 56-аас дээш насны хүмүүс байна. Нийт цаачин өрхийн 74,7 хувь буюу 37 нь нэн ядуу, 19 нь ядуу амьдралтай байна. Баруун тайгад 28 өрхийн 132, Зүүн тайгад 24 өрхийн	=

			111, бүгд 243 хүн урцанд амьдарч байгаагийн 112 нь эрэгтэй, 131 нь эмэгтэй юм.		
		Цаачдын хүүхдийн сургууль завсардалт буурсан хувь, тэднээс сургалт үйлдвэр-лэлийн төв, их, дээд сургуульд суралцагчдын тоо, мэргэжил эзэмшиж орон нутагтаа ирж ажиллагсдын тоо;	Энэ шалгуур үзүүлэлтийг дүгнэх хугацаа болоогүй байгаа.	=	
		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт, бууралт, хөрөнгө оруулалтын нийгмийн үр ашиг болон иргэдийн санал, гомдлын байдал;	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эд зориулан 2009 онд улсын төсвөөс 133.7 сая төгрөг зарцуулсан.	=	
		Нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдвал зохих иргэдийн хамрагдалтын хувь хэмжээ.	52 өрхөд дэмжлэг үзүүлэх	Хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс 1 удаа буцалтгүй туламж болгон 62,5 сая төгрөгийг Хөвсгөл аймагт олгосон. Энэ хөрөнгөөр тайгад амьдардаг цаачин өрхөд нийтдээ 104 адуу, 560 ямаа, 2600 метр бризент, 52 ширхэг радио олгогдсон байна.	100 %
		<b>Гүйцэтгэлийн дундаж хувь</b>		<b>88.0</b>	
6.	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн жилүүдэд цаа бугын тоо өсч байна. Өнгөрсөн 2009 оны байдлаар баруун, зүүн тайгын 65 өрхөд 1187 цаа үржүүлж байгаа нь 2006 онтой хаьцуулахад 38,2 хувиар өсч 328 толгойгоор нэмэгдсэн байна.</li> <li>- Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд “Цаатан” фестиваль уламжлал болон зохион байгуулагдсан.</li> <li>- Нийт 976 цаа бугыг мал үржлийн ангилалт, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан.</li> <li>- Гадаад орноос 16 цаа буга худалдан авсан.</li> <li>- Цаатан иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд нийт 54 өрхийг хамруулсан.</li> </ul>			
7.	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	<ul style="list-style-type: none"> <li>- Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд “Цаатан” фестивалийг уламжлал болгон зохион байгуулдаг болсон нь хөтөлбөрийг</li> </ul>			

		<p>сурталчлах, цаачдад аялал жуулчлалын талаар анхан шатны мэдлэг олгох чухал ач холбогдолтой арга хэмжээ болж байна.</p> <p>- Нийт цаа бугыг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад лабораторийн шинжилгээ хийхэд халдварт, паразит өвчний голомт илрээгүй байна.</p> <p>- Цагаан нуур суманд амьдарч байгаа 208 цаатан иргэний цусны бүлгийг анх удаа тодорхойлсон байна.</p> <p>- 2009 оны байдлаар Цаатан өрхийн ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн сургууль завсардалт байхгүй болсон байна.</p>
8.	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	Хөтөлбөрийн хүрээнд 2009 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх талаар санаачлага муутай ажилласны улмаас бусад салбарын төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүрэн хэрэгжээгүй байна.
9.	Эдгээрээс гарах арга зам	Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар жилийн эцэст тайлан бичиж, түүнийг үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлдэг болох талаар МААБХЗГ анхаарч ажиллах шаардлагатай.
10	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаарх үнэлгээ	ЭМЯ, БСШУЯ, ТЭХЯ, ЭМЯ, БОЯ-тай хамтран хэрэгжүүлэх зарим ажлууд бүрэн хэрэгжээгүй байна. Цаашид салбар хоорондын ажлын уялдааг сайжруулж төлөвлөгдсөн ажлыг хугацаанд нь хэрэгжүүлэх талаар хөтөлбөрийг зохицуулах үндэсний зөвлөл, хөтөлбөр хэрэгжүүлэх аймгийн салбар зөвлөл анхаарч ажиллах шаардлагатай. Мөн зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд холбогдох ТББ-уудтай хамтран ажиллах талаар санаачлага муутай ажиллаж байна.
11	Хөтөлбөрийн талаарх яамны санал /өөрчлөн сайжруулах болон бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар гэх мэт/	Хөтөлбөр 2008 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2008-2009 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүнг 2010 оны 2 дугаар сард ХХААХҮЯ-ны ТНБД-ын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан. Хөтөлбөрийг ерөнхий төлөвлөгөөний дагуу цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг дэмжиж байна.
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаарх санал /дэд хөтөлбөртэй байх, тухайн аймаг заавал хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох гэх мэт/	Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг сурталчлан таниулах, төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Хөвсгөл аймаг болон Цагааннуур сумын төрийн байгууллагуудын оролцоо, санаачлага хангалттай сайн байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА